



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Албан томилолтоор ажиллуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам"-ын 11.1.1, 11.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийг эзэмшүүлэх 2024 оны гэрээний хэрэгжилтийг дүгнэх, "Тооллогын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 481 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хуваарь, удирдамжийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн ажиллахад шаардагдах зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Алба хаагчдын томилолтын зардлыг зохих журмын дагуу тооцож, дотоод томилолтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Отгонтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132003189

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2025 оны 06 дугаар сарын 28-ны/ний
өдрийн 11 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

“ТӨРИЙН ӨМЧИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ”-Г ДҮГНЭХ АЖЛЫН (АЛБАН ТОМИЛОЛТ) УДИРДАМЖ

Зорилго:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 тогтоол, тус тогтоолоор баталсан аргачлалын дагуу Төрийн өмчийг эзэмшүүлэх 2024 оны гэрээний биелэлтийг тухайн аймаг, нийслэл дэх байгууллагаас сонгон хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, хөрөнгийн хөдөлгөөн, бүртгэл, мэдээ тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тайлагналтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн байдал, Төрийн болон орон нутгийн өмчийн цахим мэдээллийн системд захиргааны статистикийн мэдээг оруулсан байдалд үнэлэлт дүгнэлт гаргах, аймаг, орон нутагт байгаа бүх төрийн өмчит байгууллагыг хамруулан сургалт зохион байгуулж тооллого, өмч эзэмшлийн гэрээний дүнгээр гарсан зөрчил дутагдлын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн нар

Ажиллах хугацаа:

2025 оны 6 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн 9 дүгээр сарыг 30-ны өдөр хүртэл.

1. Ажлын хэсэг томилогдсон аймгийн Орон нутгийн өмчийн газартай хамтран төрийн өмчит хуулийн этгээдийн “Өмч эзэмшүүлэх гэрээ”-г дүгнэх ажлыг хийж гүйцэтгэнэ.
2. Ажлын хэсэг аймагт үйл ажиллагаа явуулж буй бүх төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, нягтлан бодогч, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга нарыг оролцуулан сургалт зохион байгуулна.
3. Орон нутагт ажиллахдаа үл хөдлөх хөрөнгөгүй, зөвхөн хөдлөх хөрөнгө бүхий хуулийн этгээдийн гэрээг цахимаар дүгнэж өнгөрсөн жилийн гэрээний дүнг тайланд нэгтгэж, үл хөдлөх хөрөнгө бүхий хуулийн этгээдэд биечлэн очиж гэрээг дүгнэнэ.
4. Аймгийн төвөөс алслагдсан болон сумдад байгаа хуулийн этгээдийн гэрээ дүгнэх ажлыг цахимаар хийж гүйцэтгэнэ. Цахимаар гэрээ дүгнүүлж буй хуулийн этгээд нь холбогдох баримтыг томилолтоор ажилласан болон салбар хариуцсан мэргэжилтнүүдэд илгээж, гэрээгээ дүгнүүлнэ.
5. Нийслэлд байрлах төрийн өмчит хуулийн этгээдийн гэрээг дүгнэх ажлыг нийт мэргэжилтнүүд хамтран хариуцан хийж гүйцэтгэнэ. Салбар нэгжтэй, томоохон аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдийн гэрээ дүгнэх ажлыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн албан хаагчид хамтран хийж гүйцэтгэнэ.

6. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ дүгнэх ажилд дараах асуудал болон тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянаж, үнэлэлт дүгнэлт өгнө:

- Засгийн газрын 2022 оны 481 дүгээр тогтоолын хэрэгжилтийн байдлыг хянаж, дүгнэлт гаргах
- Газар эзэмших эрхийн бүртгэлд ямар зөрчил байсан, түүнийг хэрхэн шийдвэрлэснийг системээс тодруулж, үнэлэлт дүгнэлт өгөх
- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажил байдалд үнэлгээ өгөх
- Төрийн өмчит бүх байгууллагаар орж үзэх, барилга байгууламжид үзлэг хийх явцад түрээсийн асуудлыг шалгах
- Дуудлагын худалдаанд онцгой анхаарал хандуулж, холбогдох журам, зааврын дагуу явуулсан эсэхийг нягтлах,
- Түрээсийн гэрээ байгуулсан байдал, бодит түрээс, төлбөр төлөлт, сонгон шалгаруулалтын баримттай танилцан дүгнэлт гаргах.
- ТӨБЗГ-ын хөрөнгө актлах тухай тогтоолыг хэрхэн хэрэгжүүлсэн талаар тогтоол тус бүрээр, байгууллага тус бүрээр нягтлан шалгаж, дүгнэлт бичих;
- Төрийн өмчийн мэдээллийн системийн програм хангамжийн 2023 оны өндөрлүүлэлт, системд оруулсан мэдээллийн дүүргэлт, чанар, иж бүрдэл зэргийг хянан дүгнэлт өгөх.

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгагдсан хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгч, ашиглалтын гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах.

Ажлын тайланг цахим системд оруулж, нэгдсэн тайлан бэлтгэж дүнг 12 дугаар сард багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд оруулж танилцуулна.

----- оОо -----

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын
2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн
2025.02.28 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТ ХЭЛТСИЙН 2025 ОНД
ӨМЧ ЭЗЭМШЛИЙН ГЭРЭЭ ДҮГНЭХ ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Аймгийн нэр	Ажлын хэсэг		Ажил- лах хүний тоо	Ажил- лах хоног	Томилолтын зардал	Замын зардал (аймаг хоорондын автомашин /шатахуун/ унаа)	Нийт зардал
		Нэр	Албан тушаал					
	Говь-Алтай, Өвөрхангай, Баянхонгор							
1	Говь-Алтай			2	4	1,360,000.00		2,468,800.00
2	Баянхонгор	Мэргэжилтэн	М.Баярмаа	2	3	1,020,000.00	1,108,800.00	1,020,000.00
3	Өвөрхангай		Б.Балдорж	2	3	1,020,000.00		1,020,000.00
	дүн				10	3,400,000.00	1,108,800.00	4,508,800.00
	Дархан, Сэлэнгэ							
4	Дархан-Уул			2	3	1,200,000.00		1,313,400.00
5	Сэлэнгэ, /Зүүнхараа/	Мэргэжилтэн	Д.Тунгалагтуул Р.Ширчинням	2	4	1,360,000.00	113,400.00	1,589,320.00
	дүн				7	2,560,000.00	342,720.00	2,902,720.00
	Булган, Хөвсгөл, Орхон							
6	Хөвсгөл			2	4	1,360,000.00		2,147,752.00
7	Орхон	А/мэргэжилтэн, мэргэжилтэн	Б.Мөнхбаатар Б.Балдорж	2	4	1,600,000.00	787,752.00	1,600,000.00
8	Булган			2	3	1,020,000.00		1,020,000.00
	дүн				11	3,980,000.00	787,752.00	4,767,752.00
	Увс, Ховд, Баян-Өлгий							
9	Баян-Өлгий			2	4	1,360,000.00		2,216,800.00
10	Увс	А/мэргэжилтэн, мэргэжилтэн	Д.Батболд П.Уранмандах	2	4	1,360,000.00	856,800.00	1,601,920.00
11	Ховд			2	4	1,360,000.00	241,920.00	2,267,200.00
	дүн				12	4,080,000.00	907,200.00	6,085,920.00
	Өмнөговь, Дундговь, Төв						2,005,920.00	
12	Өмнөговь			2	4	1,360,000.00		1,993,024.00
13	Дундговь	А/мэргэжилтэн, мэргэжилтэн	Д.Батболд Л.Гэрэлмаа	2	3	1,020,000.00	633,024.00	1,020,000.00
14	Төв			2	3	1,020,000.00		1,020,000.00
	дүн				10	3,400,000.00	633,024.00	4,033,024.00
	Завхан, Архангай, Өвөрхангай							
15	Архангай			2	3	1,020,000.00		2,431,200.00
16	Өвөрхангай /Хархорин/	Мэргэжилтэн	Ц.Баясгалан П.Улаансүх	2	2	360,000.00	1,411,200.00	360,000.00

Д/д	Аймгийн нэр	Ажлын хэсэг		Ажил- лах хүний тоо	Ажил- лах хоног	Томилолтын зардал	Замын зардал (аймаг хоорондын автомашин /шатахуун/ унаа)	Нийт зардал
		Нэр	Албан тушаал					
17	Завхан (Тосонцэнгэл)			2	4	1,360,000.00		1,360,000.00
	Дүн				9	2,740,000.00	1,411,200.00	4,151,200.00
	Дорнод, Хэнтий, Сүхбаатар							
18	Дорнод			2	4	1,360,000.00		1,360,000.00
19	Хэнтий	А/мэргэжилтэн, мэргэжилтэн	Б.Мөнхбаатар Ц.Баясгалан	2	3	1,020,000.00	730,800.00	1,750,800.00
20	Сүхбаатар			2	3	1,020,000.00		1,020,000.00
	Дүн				10	3,400,000.00	730,800.00	4,130,800.00
	Дорноговь, Говь-Сүмбэр, Замын-Үүд							
21	Говь-Сүмбэр			2	3	1,020,000.00		1,675,200.00
22	Дорноговь	Дарга, мэргэжилтэн	Д.Нарангэрэл Р.Ширчинням	2	3	1,020,000.00	655,200.00	1,020,000.00
23	Замын-Үүд			2	4	720,000.00		720,000.00
	Дүн				10	2,760,000.00	655,200.00	3,415,200.00
	Нийслэлийн алслагдсан дүүрэг							
24	Багануур			2	2	800,000.00		1,112,750.00
25	Багахангай	Дарга, мэргэжилтэн	Д.Нарангэрэл Г.Одгэрэл	2	1	400,000.00	312,750.00	400,000.00
26	Налайх			2	1	400,000.00		400,000.00
	Дүн				4	1,600,000.00	312,750.00	1,912,750.00
	Улаанбаатар хот /дүүрэг/							35,908,166.00
27	Сүхбаатар			2			300,000.00	300,000.00
28	Хан-Уул			2			300,000.00	300,000.00
29	Баянгол			2			300,000.00	300,000.00
30	Сонгинохайрхан			2			300,000.00	300,000.00
31	Баянзүрх			2			300,000.00	300,000.00
32	Чингэлтэй			2			300,000.00	300,000.00
	Дүн							1,800,000.00
	Нийт зардал							37,708,166.00

ХЯНАСАН:

Н.ГАНБОЛД /ЗУХ-ИЙН ДАРГА/

Д.ОТГОНТУЯА /ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ/

БОЛОВСРУУЛСАН:

М.БАЯРМАА /ТӨБАХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН/